

115

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2011 оныес дүгээр сарын 12 ны өдрийн
1/38 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт.

**АХМАД ХӨЛ БӨМБӨГЧДИЙН
ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ**

№	Зардлын нэр	Дүн /төг/
1.	Тамирчдын шагнал 1-р байр 15 x 8000 ₮ = 120.000 төгрөг 2-р байр 15 x 6000 ₮ = 90.000 төгрөг 3-р байр 15 x 5000 ₮ = 75.000 төгрөг	285.000
2.	Шүүгчдийн хөлс 8 хүн x 2 өдөр x 15.000 төг	240.000
3.	Медаль	180.000
НИЙТ ДҮН:		705.000

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын 2011 оны ...^{ee} дүгээр сарын ...^д ны өдрийн ...^д дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

АХМАД ХӨЛ БӨМБӨГЧДИЙН
ТЭМЦЭЭНИЙ ШҮҮГЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Шүүгчдийн овог, нэр	Байгууллага	Гүйцэтгэх үүрэг	Зэрэг
1.	А.Цэрэнбаатар		Ерөнхий шүүгч	У/Ш
2.	Д.Амарбат		Нарийн бичгийн дарга	У/Ш
3.	О.Батсайхан		Шүүгч	У/Ш
4.	Т.Эрдэнэбаяр		Шүүгч	У/Ш
5.	Ц.Нямхүү		Шүүгч	У/Ш
6.	Б.Ганбаатар		Шүүгч	У/Ш
7.	С.Батхүү		Шүүгч	У/Ш
8.	Ц.Жаргалсайхан		Шүүгч	У/Ш

БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА



Ж.ГАНБОЛД

АХМАД БАГШ, ДАСГАЛЖУУЛАГЧ Н.ЛУВСАНДОРЖИЙН НЭРЭМЖИТ
УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ХӨЛБӨМБӨГИЙН
ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

НЭГ. Зорилго

Ахмад багш, дасгалжуулагч Н.Лувсандоржийн алдрыг мөнхжүүлэх, олон түмэнд сурталчилах, хөлбөмбөгийн спортыг хөгжүүлэх, ахмад хөлбөмбөгчдийн Улаанбаатар хотын аварга багийг шалгаруулахад оршино.

ХОЁР. Тэмцээний удирдлага, зохион байгуулалт

- Тэмцээнийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүн удирдан зохион байгуулна.
- Тэмцээнд оролцох багийн тооноос шалтгаалан тоглолтын системийг техникийн зөвлөлгөөн дээр шийдвэрлэнэ.
- Тэмцээнд 55-аас дээш насны 13 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй баг оролцох ба талбайд 9 тоглогч тоглоно. Сэлгээ хийх тамирчдын тоонд хязгаар тогтоохгүй.
- Тэмцээн Нийслэлийн Ерөнхий боловсролын 3-р сургуулийн хөлбөмбөгийн талбайд 2011 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр болно.

ГУРАВ. Тэмцээнийг дүгнэх, техникийн зөвлөгөөн

Техникийн зөвлөгөөн 09 дүгээр сарын 23-ны өдрийн 10.00 цагт Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын "Хангарьд" ордны 509 тоот өрөөнд болно. Тэмцээнд эхний гурван байр шалгаруулж, алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

Жич: Баг бүр эмчийн магадалгаа бүхий албан ёсны мэдүүлэгийг техникийн зөвлөлгөөн дээр авч ирнэ. Харилцах утас: 328977, 99144011

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР



114

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Ахмад хөл бөмбөгчдийн
тэмцээн зохион байгуулах тухай

Нийслэлийн Засаг даргын 2009-2012 оны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн Эдийн засаг, нийгмийн 2011 оны зорилт, Засгийн газрын 246 дугаар тогтоолыг үндэслэн
ТУШААХ НЬ:


Нэг. Улаанбаатар хотын Ахмад хөл бөмбөгчдийн аварга шалгаруулах тэмцээнийг 2011 оны 09 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн талбайд зохион байгуулсугай.

Хоёр. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Тэмцээнийг зохион явуулахад шаардагдах 705.000 /долоон зуун таван мянга/ төгрөгийг арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч Ж.Цэдэнсодномд зөвшөөрсүгэй.

Дөрөв. Тэмцээний бэлтгэл ажлыг урьдчилан хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн Б.Батсайханд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД